



ТӨВ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 02 өдөр

Дугаар А/628

Зуунмод

Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3, 35 дугаар зүйлийн 35.1, 35.3, 46 дугаар зүйлийн 46.5.5, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.1 дэх заалт, 2017 оны Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын хамтарсан А-297, 360 тоот тушаалын 1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж байгаа болон үйлдсэн тухай үндэслэлтэй мэдээллийг цуглуулж, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, Улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй Илрүүлэлт-Оргодол-2022 арга хэмжээний хүрээнд иргэдээс төлбөртэй мэдээлэл хүлээн авах тухай зурагт самбарыг байршуулахад шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Тус арга хэмжээнд шаардлагатай 2,000,000 (хоёр сая) төгрөгийг аймгийн төсвийн хуваарилагдаагүй зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт)-т, зарцуулахыг аймгийн Цагдаагийн газар (Ч.Алтанхуяг)-т тус тус зөвшөөрсүгэй.

3. Мэдээллийн нууцыг чанд хадгалж, шаардлагатай бол мэдээлэгчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг зохион байгуулж, үр дүнтэй ажиллахыг Цагдаагийн газар (Ч.Алтанхуяг)-т, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, үр дүнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Б.Ганхуяг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Д.МӨНХБААТАР



